Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 21-ээс 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэв.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг. Булган сумын төсөвт байгууллагуудын 2019, 2020 оны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд шалгалт хийсэн байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,799.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 96.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 76.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 236.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 215.7 сая төгрөг болж 21.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	236.9	215.9	-21.0	100%
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>236.9</b>	<b>215.7</b>	<b>-21.0</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 215.9 сая төгрөг байгаагаас 192.6 сая төгрөг нь төрийн сангийн харилцахад, 23.4 сая төгрөг нь Эмийн эргэлтийн сангийн арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сангийн харилцах дансанд байгаа 182.6 сая төгрөгийн 67.2 сая төгрөг нь сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 39.5 сая төгрөг нь ОНХСангийн, 78.0 сая төгрөг нь СХСангийн, 7.6 сая төгрөг нь байгаль орчныг хамгаалах сангийн дансны үлдэгдэл байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Тус сумын ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.*

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 271.6 сая, эцсийн үлдэгдэл 221.3 сая төгрөг болж 50.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Ажиллагчидтай холбогдсон авлага	17.4	4.1	-13.3
Бусад авлага	2.2	0.5	-1.7
Зээлийн авлага	252	216.7	-35.3
<b>Дүн</b>	<b>271.6</b>	<b>221.3</b>	<b>-50.3</b>

Эх сурвалж: Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 216.7 сая төгрөг байгаа нь нийт авлагын 97.9 хувийг эзэлж байна. Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

#### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 317.2 сая, эцсийн үлдэгдэл 369.1 сая төгрөг болж, 51.9 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	13.7	15.1	1.4
Бэлэн бүтээгдэхүүн	0.2	0.2	0
Хангамжийн материал	302.5	353	50.5
Мал амьтад	0.8	0.8	0
<b>Дүн</b>	<b>317.2</b>	<b>369.1</b>	<b>51.9</b>

Эх сурвалж: Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 369.1 сая төгрөг болж 51.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 731.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 94.7 сая төгрөгийн материал үнэгүй төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаандаа 743.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 18.8 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, 11.6 сая төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал 0.9 сая, Засаг даргын тамгын газар 63.2 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 99.4 сая, 2 дугаар сургууль 41.0 сая, 3 дугаар сургууль 34.2 сая, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 39.2 сая, 2 дугаар цэцэрлэг 22.1 сая, Эрүүл мэндийн төв 54.5 сая, Соёлын төв 5.6 сая, Эргэлтийн эмийн санг 8.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд тусгагдсан 62.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллого хийгдээгүй, үлдэгдэлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.

Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн бүртгэл тооцоо хангалтгүй хийгдсэн, төвийн эрхлэгч 8.2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийг эмийн захиалга бичиж, хяналтгүйгээр анхан шатны бүрдэл дутуу баримтаар шууд зарцуулалт хийсэн.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,622.4 сая, эцсийн үлдэгдэл 8,365.2 сая төгрөг болж, 257.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,462.20	8,205.20	-257.00
Биет бус хөрөнгө	160.2	160.0	-0.20
<b>Дүн</b>	<b>8,622.40</b>	<b>8,365.20</b>	<b>-257.20</b>

Эх сурвалж: Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 16.2 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 290.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 180.3 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна. Үндсэн хөрөнгөд нийт 542.3 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд тусгагдсан 805.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй, хөрөнгийн үлдэгдэлийг тооцоо хийж баталгаажуулаагүй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 75.2 сая, эцсийн үлдэгдэл 64.7 сая төгрөг болж, 10.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	67.2	38.1	-29.1	58.9%
Байгууллагад төлөх өглөг	1.7	0.3	-1.4	0.4%
Хувь хүмүүст төлөх өглөг	6.3	26.3	20	40.7%
<b>Нийт дүн</b>	<b>75.2</b>	<b>64.7</b>	<b>-10.5</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэл 64.7 сая төгрөгийн 58.9 хувийг буюу 38.1 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой өглөг, 40.7 хувийг буюу 26.3 сая төгрөгийг хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна.

Өр төлбөрийн 44.5 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 12.5 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 6.5 сая төгрөг нь сумын Засаг даргын тамгын газрын, 1.2 сая төгрөг нь Соёлын төвийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өглөгтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 9,373.1 сая, эцсийн үлдэгдэл 9,107.1 сая төгрөг болж, 266.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,386.40	2,386.40	0.00	26.2%
Хуримтлагдсан үр дүн	3,107.60	2,845.00	-262.60	31.2%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,879.10	3,875.70	-3.40	42.6%
<b>Дүн</b>	<b>9,373.10</b>	<b>9,107.10</b>	<b>-266.00</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,107.1 сая төгрөг болж 266.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 266.0 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт буюу акталсан хөрөнгийн үнэлгээний бууралт 3.4 сая төгрөгөөр буурсан байна. Хуримтлагдсан үр дүн 2,845.0 сая төгрөг болж 262.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 266.0 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 3.4 сая төгрөг гарснаас шалтгаалсан байна.

### 3.5.10. Орлогын данс

Булган сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 278.7 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 3,471.9 сая, орон нутгийн төсвөөс 454.7 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 281.9 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 38.8 сая, нэмэлт санхүүжилтээр 239.7 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 280.1 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 290.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 96.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч нийтдээ 5,324.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 5,324.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 266.2 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлогууд байна.

### 3.5.11 Зардлын данс

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 5,127.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 327.6 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Нийт зардлын 97.7 хувь нь бараа үйлчилгээний зардал, 2.3 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томиллолт, зочны зардал, хураамж, бараа үйлчилгээний бусад зардууд 3.7 саяаас 196.7 сая төгрөгөөр өссөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 11.4 сая, урсгал шилжүүлгийн зардал 18.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсөвт байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийг ИТХурал 0.9 сая, ЗДТГ 5.5 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 1.5 сая, 2 дугаар сургууль 1.1 сая, 3 дугаар сургууль 4.3 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Засаг даргын тамгын газар гэрэл цахилгаан, түлш халаалт, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хүгшил, урсгал засварын зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлуудаас 2.1 сая төгрөгийг цалингийн зардалд, түлш халаалтын зардлаас 1.3 сая төгрөгийн тээвэр шатахууны зардалд, хичээл практикийн зардлаас гэрэл цахилгааны зардалд 0.1 сая буюу нийт 3.5 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд зохих зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулжээ

Эрүүл мэндийн төв нэр бүхий ажилтанд 0.3 сая төгрөгийн цалинг илүү олгож суутгаж аваагүй, тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй.

Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль тээвэр шатахууны зардалд зарцуулсан 3.7 сая төгрөгийн жагсаалтад, хэрэглэсэн албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж баримтжуулаагүй.

Засаг даргын тамгын газар тайлант хугацаанд 21.9 сая, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 8.9 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 17.3 сая, 2 дугаар сургууль 5.4 сая, Эрүүл мэндийн төв 54.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийн журналуудыг бүрэн хөтлөөгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

### **3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 4,862.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 4,408.1 сая төгрөгийг урсгал зардалд, 454.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 3,471.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 667.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 281.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 38.8 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 200.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 203.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Булган сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 4,614.3 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 3,471.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 698.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 38.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 281.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 128.3 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 128.3 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Нийт санхүүжилтээс 4.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба үндсэн үйл ажиллагааны орлого 71.7 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс 2.9 сая, орон нутгийн төсвөөс 1.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4695.3 сая төгрөг буюу 96.5 хувьтай биелэхэд сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөө 71.7 сая төгрөгөөр тасарсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Булган сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 175.6 сая төгрөгөөр баталжээ.

Сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 212.9 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 212.9 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 278.7 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 65.8 сая төгрөгөөр буюу 30.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	210.4	272.3	61.9	97.7
II.Татварын бус орлого	2.5	6.4	3.9	2.3
<b>Нийт дүн</b>	<b>212.9</b>	<b>278.7</b>	<b>65.8</b>	<b>100</b>

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 10.2 сая төгрөгөөр, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 12.9 сая төгрөгөөр, бууны албан татвар 3.8 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.4 сая төгрөгөөр, ойн нөөцийн төлбөр 4.5 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 0.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлого төлөвлөгөөний давж биелэгдэхэд улсын тэмдэгтийн хураамж 47.1 сая, хөрөнгө борлуулсны орлого 1.8 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөр 46.0 сая, хүү, торгуулийн орлогоос 3.4 сая, бусад орлого 0.5 сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансны оны эхний үлдэгдэл 30.8 сая төгрөг ба 278.7 сая төгрөгийн татварын орлого оруулж, аймгаас 454.7 сая төгрөгийн дэмжлэг авч, 698.1 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд 67.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	57.7	57.7	-
2	Сумын ЗДТГ	372.8	371.9	-
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	1,821.70	1,821.00	0.2
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	281.20	281.20	
5	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	380.70	380.00	
6	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	372.3	371.1	0

7	Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	142.4	142.1	
8	Соёлын төв	109.1	108.9	-
9	Эрүүл мэндийн төв	670.2	670.0	0.6
10	ОНХСан	454.9	416.4	15.2
11	СХС	200	75	4
	<b>Нийт дүн</b>	<b>4,863.00</b>	<b>4,695.30</b>	<b>20.00</b>

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 234.8 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 4.9 сая төгрөгийн нийт 239.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 98.1 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 11.0 сая, хангамж, бараа материалын зардалд 22.6 сая, нормативт зардалд 50.2 сая, томилолтын зардалд 0.7 сая, бараа үйлчилгээний зардалд 8.9 сая, урсгал шилжүүлгийн зардалд 44.8 сая, хөрөнгийн зардалд 3.4 сая төгрөгийг буюу нийтдээ 239.6 сая төгрөгийг зарцуулж, 0.01 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган сумын ТТЗ нь 2021 онд нийт 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 67 мэдээллийг хугацаандаа байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Төвлөрүүлэн захирагчийн 1, 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг оруулаагүй, хагас жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй, таван сая төгрөгнөөс дээш татварын орлогын 186.7 сая төгрөгийн 7 орлогын гүйлгээг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш зарлагын 698.1 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 52.2 хувьтай байна.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 11 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах алдаа, зөрчил илэрсэн.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Иргэдийн төлөөлөгчдийн хурал төсвийн гүйцэтгэлийн 3 дугаар улирлын мэдээг хугацаа хоцроож оруулсан, 0.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн 1 шийдвэр, жилийн эцсийн санхүүгийн тайланг байршуулаагүй.*

*Сумын ЗДТГ өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, 6.4.8 -д заасан 220.7 сая төгрөгийн 13 мэдээллийг байршуулаагүй.*

*Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 -д заасан 30.8 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй байна. Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.*

*Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 -д заасан 7.6 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй.*

*Эрүүл мэндийн төв тайлант оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл 26.9 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээг оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 838.7 сая төгрөгийн 25 гүйлгээг оруулаагүй, 26.9 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг дутуу оруулсан, 42.2 сая төгрөгийн өр үүсгэсэн тухай 5 шийдвэрийг байршуулаагүй, өмнөх онд шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан*

*Орон нутгийн хөгжлийн сангийн шилэн данстай холбоотой өмнөх аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн 1,2,3,4 дүгээр улирлуудын мэдээг оруулаагүй, 200.0 сая төгрөгийн 1 тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг оруулаагүй, 284.3 сая төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 13 мэдээллийг оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 281.9 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээг оруулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 284.3 сая төгрөгийн 13 зарлагын гүйлгээ, 3.5 сая төгрөгийн өр үүсгэсэн 1 шийдвэрийг байршуулаагүй.*

*Сум хөгжүүлэх сангийн шилэн данстай холбоотой өмнөх аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн 1, 2, 3, 4 дүгээр улирлуудын мэдээг оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 18.7 сая төгрөгийн 3 орлогын гүйлгээг оруулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая*

*төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20.0 сая төгрөгийн 3 зарлагын гүйлгээ, 74.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн 19 шийдвэрийг байршуулаагүй.*

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд мэдээлбэл зохих 79 мэдээллээс 25 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй зөрчлийн дүнгээр зөвлөмж өгөгдсөн ба хэрэгжилтийг шалгахад зөрчлийг давтан гаргасан, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

*Хүснэгт: №8* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт / сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1				1		0%
<b>Нийт</b>	<b>1</b>				<b>1</b>		<b>0%</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, 5 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 3 сангийн тайланг нэгтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгч, Ерөнхий боловсролын 1, 2, 3 дугаар сургууль, Хүүхдийн 1,2 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төрийн сан, Байгаль хамгаалах сангийн тайланг нэгтгэлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 912.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 28.0 сая төгрөгийн алдааг залруулж, 884.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, санхүүгийн албаны даргын албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Эргэлтийн эмийн сангийн Санхүүгийн байдлын тайланд авлагыг 0.2 сая төгрөгөөр дутуу бараа материалыг 9.4 сая төгрөгөөр илүү, тайлант үеийн үр дүнг 9.2 сая төгрөгөөр илүү, Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нормативт зардлыг 8.1 сая төгрөгөөр дутуу, бараа үйлчилгээний зардлыг 1.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нийт 28.0 сая төгрөгийн алдааг залруулав.

#### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчид шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 884.8 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,428.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

ОНХС, СХСангуудын тайланд 62.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Эрүүл мэндийн төвд 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, сумын нийт төсвийн байгууллага болон ОНХС, СХСанд 3,276.3 сая төгрөгийн 13 албан шаардлага, ИТХ, ЗДТГ, Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Эрүүл мэндийн төвүүдэд 90.0 сая төгрөгийн 5 заалт бүхий зөвлөмж, Булган сумын ЗДТГ ын нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулсан алдаа		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>A</b>	<b>B</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>11</b>	<b>12</b>	<b>13</b>	<b>14</b>	<b>#</b>	<b>16</b>	<b>17</b>	<b>18</b>
1	ИТХурал	2	10.0					1	1.1	1	8.9		
2	ЗДТГазар	5	1,120.1					2	1,116.6	1	3.5	1	
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	3	49.6					2	32.3	1	17.3		
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	3	14.1					2	8.7	1	5.4		
5	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	2	8.0					2	8.0				
6	Эрүүл мэндийн төв	4	998.1			1	0.3	2	942.9	1	54.9		
7	Орон нутгийн хөгжлийн сан	2	1,063.0	1	9.0			1	1,054.0				
8	Сум хөгжүүлэх сан	2	166.0	1	53.3			1	112.7				
<b>Дүн</b>		<b>23</b>	<b>3,428.9</b>	<b>2</b>	<b>62.3</b>	<b>1</b>	<b>0.3</b>	<b>13</b>	<b>3276.3</b>	<b>5</b>	<b>90.0</b>	<b>1</b>	<b>0</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1 Албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн талаар

###### 1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч зурж, тайлан баланс гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын ТТЗ	7	912.8	5	28.0			1	884.8	1	